



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/403

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 55 дугаар зарлиг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 5 дугаар сарын 28-ний өдрийн 18 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн захирамжлах нь:

1. "Алдарт эх" одонгоор шагнагдсан ээжүүдийн шагнал гардуулах ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагаанд 3,708,000 (гурван сая долоон зуун найман мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Шаардагдах 3,708,000 (гурван сая долоон зуун найман мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын
20.14. оны 06 дугаар сарын 04 -ны
өдрийн 403 дугаар захирамжийн
хавсралт

Зардал	
Дурсгалын зураг	178*11,000=1,958,000
Хэвлэл, мэдээллийн зардал	1,570,000
Баннер	180,000
Нийт дүн	3,708,000

--oOo--

